



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdeneslt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.11.22 № 01/2496  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ  
ЭТГЭЭДҮҮДЭД**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240102422 дугаартай “Аж ахуйн бараа материал” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт *2* хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124051307



Тодруулгын хариу

Тендерийн нэр	Аж ахуйн бараа материал нийлүүлэгчийг сонгох
Тендерийн дугаар	ЭТТХК/20240102422
Тендер зарласан огноо	2024 оны 10 дугаар сарын 06
Тендер нээх огноо	2024 оны 11 дүгээр сарын 28

**Тодруулга №1**

Тодруулга	Хариу												
<p>Жалюзан хөшигний материалын урт хамгийн ихдээ 3м байдаг. Оффисийн барилгын хөшигний урт 3650мм-7100мм хүртэл байна. Иймээс 3650мм-ийг 1825мм+1825мм=3650мм, 7100мм-ийг 2366мм+2366мм+2366мм=7100мм гэж хийх шаардлагатай болно. Ингэж хийхийн тулд тус бүр нь зам, тус бүрт нь мотор хийнэ. Хамгийн гол зүйл нь моторын тоо нэмэгдэнэ. Тендерийн бичиг баримт дээр 49ш хөшиг хийх шаардлагатай хирнээ 16ш мотор гэсэн нь яг юу гэсэн үг вэ? Уг нь зам бүр дээр мотор байх ёстой буюу 49ш мотор байх ёстой. 33ш мотор нь байгаа гэсэн үг үү. Хөшигний материалын өргөнөөс шалтгаалж урт хөшиг хийгдэх газруудад тэнцүү хуваалттайгаар хөшгөө хийхээр мотор нэмэгдэж болох уу? Үүн дээр тодруулга өгнө үү.</p> <p>Тус тендерийн баримт бичгийн Багц 2-т тусгагдсан техникийн тодорхойлолтын 1-т 1-10 хүртэлх өөр төрлийн хэмжээтэй цонхны харьцаа өгөгдсөн байх ба том цонхонд нэмэлтээр автомат ажиллагаагаар хааж, нээдэг тоноглолтой байх шаардлага тавьсан байна. Гэвч том цонх гэх ойлголтод хэддүгээр дэс дугаартай ямар хэмжээтэй цонхыг ойлгох талаар тодруулгыг ирүүлж өгнө үү.</p>	<p>Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Салбарын нүүрс баяжуулах үйлдвэрийн оффис болон ажилчдын амрах байранд очиж хэмжээ авч техникийн тодорхойлолтод заасан хэмжээгээр хийгдэнэ.</p> <p>Багц-2: Аж ахуйн бараа, материалын техникийн тодорхойлолтын № 1 Хөшиг /Оффисын барилга/-д заасан дараах хэмжээст хөшгөнд 16 ширхэг мотор хийнэ.</p> <table border="1" data-bbox="865 1312 1385 1491"> <thead> <tr> <th>№</th> <th>Цонхны харьцаа</th> <th>Нийт тоо, ш</th> <th>Нийт талбай, м<sup>2</sup></th> </tr> </thead> <tbody> <tr> <td>6</td> <td>5000x4900</td> <td>4</td> <td>98.0</td> </tr> <tr> <td>10</td> <td>7100x4900</td> <td>4</td> <td>139.2</td> </tr> </tbody> </table>	№	Цонхны харьцаа	Нийт тоо, ш	Нийт талбай, м <sup>2</sup>	6	5000x4900	4	98.0	10	7100x4900	4	139.2
№	Цонхны харьцаа	Нийт тоо, ш	Нийт талбай, м <sup>2</sup>										
6	5000x4900	4	98.0										
10	7100x4900	4	139.2										

**Тодруулга №2**

Тодруулга	Хариу
Тус тендерийн нийт төсөвт өртөг багцуудын төсөвт өртгөөс зөрүүтэй байгааг дахин хянаж	

өгнө үү. Жишээ нь Багц №1-ийн төсөвт өртөг нь тоо ширхэгээр тооцоолход зах зээлийн үнээс хэт доогуур байгааг нарийвчлан шалгаж өгнө үү.

Энэ тендерийн "Багц-2"-ийг "Хөшиг" болон "Хогийн сав, аж ахуйн хэрэглээний бараа" гээд 2 салгаад оруулж болохгүй юу? 2 өөр чиглэлийн бараа бүтээгдэхүүнийг нэг багц болгосон нь хүндрэлтэй байна.

Тендерийн төсөвт өртөг нь 281024282 төг байгаа хирнээ "Багц-1" болон "Багц-2" тендерийн нийлбэр дүнгээс зөрүүтэй бараг 2 дахин их байна. Үүнийг залруулж өгнө үү.

Тус төсөл арга хэмжээний 3 дугаар багцын худалдан авалтыг хийх шаардлагагүй болсон тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1-т зааснаар "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах" гэсэн заалтыг үндэслэн Багц 1, 2-ыг зарласан болно.